



**ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 5/20

Чингис хот

**Б.Дарханбаатарыг төрийн нууц  
хариуцсан ажилтнаар томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 2.1, 2.4, 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам”-ын 1.2, 1.3, 2.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тагнуулын хэлтсийн 2021 оны 48/32 тоот албан бичгээр нууц хамгаалах ажилтнаар томилоход татгалзах зүйлгүй талаар ирүүлсэн тул Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Б.Дарханбаатарыг төрийн нууц хариуцсан ажилтнаар томилсугай.

2. Б.Дарханбаатарын нууц хамгаалах ажилтны цалингийн нэмэгдлийг 20 хувиар тооцож олгохыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

3. Нууц задруулахгүй байх баталгааг Б.Дарханбаатараар гаргуулан авч нэг хувийг Тагнуулын хэлтэс, нэг хувийг хувийн хэрэгт хадгалахыг Хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан ахлах мэргэжилтэн /Ж.Саруултөгс/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030082